

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Сагсай сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2026/156/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Баян-Өлгий аймаг

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас:99422227 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 99932710 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Р.Содномдаржаа

Утас: 99101563 Цахим хаяг: Uujimaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах



### БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

САГСАЙ СУМЫН ХҮҮХДИЙН  
1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Ө.ГҮЛГАЙЫМ ТАНАА

2026.02.24 № 103  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сагсай сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сагсай сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Сагсай сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг нь 2025 онд 1,225.5 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 1,208.7 сая төгрөг зарцуулж, 98.6 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

831005006073

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ж.АЙГҮЛ



Сагсай сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,225,479,400.00</b>	<b>1,208,725,177.54</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,225,479,400.00</b>	<b>1,208,725,177.54</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,219,833,800.00</b>	<b>1,203,079,577.54</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>933,147,800.00</b>	<b>929,099,177.54</b>
210101	Үндсэн цалин	579,734,600.00	578,147,677.54
210102	Нэмэгдэл	322,009,500.00	322,009,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	31,403,700.00	28,942,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>115,835,000.00</b>	<b>115,835,000.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	78,607,600.00	78,607,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,306,800.00	9,306,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,653,400.00	4,653,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,653,400.00	4,653,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,613,800.00	18,613,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>61,327,300.00</b>	<b>54,228,300.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	13,440,900.00	6,341,900.00
210302	Түлш, халаалт	46,886,400.00	46,886,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>68,566,200.00</b>	<b>62,959,600.00</b>
210502	Хоол, хүнс	68,566,200.00	62,959,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,000,000.00</b>
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,022,400.00</b>	<b>4,022,400.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,022,400.00	4,022,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>35,935,100.00</b>	<b>35,935,100.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,052,600.00	29,052,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,882,500.00	6,882,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,645,600.00</b>	<b>5,645,600.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,645,600.00	5,645,600.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,225,479,400.00</b>	<b>1,090,806,100.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,039,602,500.00</b>	<b>1,033,027,800.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,039,602,500.00	1,033,027,800.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>62,327,300.00</b>	<b>55,228,300.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	62,327,300.00	55,228,300.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>123,549,600.00</b>	<b>2,550,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,550,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	123,549,600.00	
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		140,761,394.26
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		22,842,316.72
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>37.00</b>	<b>37.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00
620003	Үйлчлэх ажилтан	19.00	19.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>37.00</b>	<b>37.00</b>
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	17.00	17.00
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	1.00	1.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	18.00	18.00

## **Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар 162.7 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрч, аудитын явцад 162.7 сая төгрөгийн алдааг залруулсан. *Залруулсан алдаа:*

- Санхүүгийн байдлын тайланд ХХОАТ-д 1.9 сая төгрөгөөр авлагыг илүү, хөрөнгийн элэгдэл буруу бодсон 0.1 сая төгрөг, тайлант үеийн үр дүн 2.0 сая төгрөгөөр зөрүүтэй гаргасан
- Санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд туслах үйл ажиллагааны орлогыг 1.8 сая төгрөгөөр илүү, улсын төсвийн санхүүжилтийг 7.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасан
- Мөнгөн гүйлгээний тайланд нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллыг 0.3 сая төгрөгөөр дутуу, төвлөрүүлэх шилжүүлгийн 7.1 сая төгрөгийг, биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлын 1.5 сая төгрөгийг бүртгээгүй орхигдуулсан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эх үүсвэрт улсын төсвийн санхүүжилтийг 2.5 сая төгрөгөөр илүү, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 3.0 сая төгрөгөөр дутуу, урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг 123.5 сая төгрөгийг тусгаагүй, зарлагын төлөвлөгөөг нийт 10.8 сая төгрөгөөр дутуу тайлагнаж төвлөрүүлэх шилжүүлгийн 7.1 сая төгрөгийг цэвэрлээгүй тайлагнасныг тус тус залруулав.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## **Зөвлөмж**

Аудитаар 24.7 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгөв.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Төсвийн зарцуулалт, хяналттай холбоотой асуудал**

#### **1.1. Илрүүлэлт:**

Цалингийн зардлын төсвөөс 17.6 сая төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооноос илүү шилжүүлж авлага үүсгэсэн, бараа үйлчилгээний бусад зардлын төсвөөс тээвэр шатахууны зардалд 7.1 сая төгрөгийг аймагт ажлаар, албан томилолт зэрэгт анхан шатны баримт бүрдэлт дутуу баримтаар зарцуулж, тооцоог зохих журмаар хийгээгүй, данснаас мөнгө шилжүүлэхдээ анхан шатны нотлох баримтгүйгээр гүйлгээ хийсэн, төсвийн зарцуулалтад зохих журмаар хяналтыг тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14 дүгээр зүйлийн 14.3-д "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ", 14.3.1-д "анхан шатны баримт бүрдүүлэх", 20.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна", 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Сагсай сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах”, 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:**

Нийгмийн даатгалын шимтгэлд илүү шилжүүлж авлагыг 2026 оны тооцоонд оруулж бүрэн барагдуулах, үндэслэлгүй авлага үүсгэхгүй байх. анхан шатны баримт бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байхыг зөвлөмж болгов.

**Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн байдлын тайланд үеийн үр дүн буруу тайланг насан	1	4,047.8			1	4,047.8	1	4,047.8				
Санхүүгийн үр дүнгийн тайлан зөрүүтэй тайлагнасан	1	8,899.0	1	8,899.0			1	8,899.0				
Мөнгөн гүйлгээний тайланд буруу тусгасан	1	8,903.9			1	8,903.9	1	8,903.9				
Төсвийн гүйцэтгэлийн тайлан зөрүүтэй тайлагнасан	1	140,906.8			1	140,906.8	1	140,906.8				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>162,757.4</b>	<b>1</b>	<b>8,899.0</b>	<b>3</b>	<b>153,858.5</b>	<b>4</b>	<b>162,757.4</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа үйлчилгээний бусад зардлын төсвөөс тээвэр шатахууны зардалд хяналт тавьж ажиллаагүй байна	1	24,744.8			1	24,744.8						
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>24,744.8</b>			<b>1</b>	<b>24,744.8</b>						

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс		
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж